



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

(2024 ОНЫ УЛИРАЛ I)



БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

'Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл', 'Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр' боловсруулах аргачлалыг үр дүнд суурилсан аргазүйд тулгуурлан боловсруулсан ба 'Улсын болон аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө' боловсруулах аргачлалыг нэгтгэн, шинэчилж ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

2024 оны 1 дүгээр сарын 3-5-ны өдрүүдэд 'Үр дүнд суурилсан арга зүйгээр Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь' сэдэвт сургалтыг ЭЗХЯ-тай хамтран төрийн захиргааны байгууллагын 150 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.

 [Мэдээ унших холбоос](#)

Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл'-ийг сайжруулах саналыг төслөөс боловсруулан ЭЗХЯ, ЗГХЭГ, ЗГХХГ болон холбогдох талуудад -т хүргүүлсэн.

'Үр дүнд суурилсан төлөвлөлт'-ийн гарын авлагын төслийг боловсруулан, холбогдох талуудын саналыг тусган сайжруулж байна.



'Үр дүнд суурилсан арга зүйгээр Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь' сургалт, 2024.01.05

ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ

2023 онд Дорноговь аймагт ‘Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт’-ыг аргачлалыг турших ажлыг хийсэн бөгөөд туршилтын үр дүнг нэгтгэсэн ‘Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт’ тайланг боловсруулан гаргалаа.

Шинэчлэгдсэн хөтөлбөр болон гарцын тодорхойлолтыг Сангийн яамны Фискал программд оруулах ажлыг хийхээр төлөвлөж байна.

Үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэн турших чиглэлд төсөл нь нийт 6 яамыг (ХНХЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, БШУЯ, ЭХЯ, ЭМЯ) сонгон авч ажиллаж байна. Сонгосон 6 ТЕЗ-ийн ‘төсвийн хөтөлбөр, гарц, арга хэмжээний ангилал, тодорхойлолт’-ыг үр дүнд суурилсан аргагүйгээр шинэчлэн боловсруулж, танилцуулах уулзалтуудыг зохион байгуулж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн олон нийтийн хэлэлцүүлэгт Дунд хугацааны төсвийн хүрээг боловсруулах олон улсын чиг хандлагын талаар танилцуулга хийсэн.



Мэдээ унших холбоо

“Монгол Улсын эдийн засгийн өсөлт 6 хувиас бууруулахгүйгээр 5-10 жил тогтвортой хадгална. Монгол Улсын Засгийн газрын өрийн хэмжээ 40 тунд ургал, гэрээг зөвхөн эдийн засгийн 10 тунд ашиглах үржлийн өсөлтөөр хийгдэнэ. Үүнийг хялбархан хийж болно.”

Төсвийн хурлын шинэчлэлийн хүрээнд шинээр зохион байгуулагдсан Төсвийн тэргүүтэй байрны зөвлөл дунд яриуцалыг биелүүлэх өмнө дэвхэж байна. Төсвийн хурлын шинэчлэлийн хүрээнд төсвийн хурлын тусгай шалгуур Монгол Улсад үзэж буй бодлогын гэгээлд дотоод орны эрсдэлийн талаар төсвийн бодлогын санхүүгийн өсөлт, өрийн өсөлт




“Монгол Улсын эдийн засгийн өсөлт 6 хувиас бууруулахгүйгээр 5-10 жил тогтвортой хадгална. Монгол Улсын Засгийн газрын өрийн хэмжээ 40 тунд ургал, гэрээг зөвхөн эдийн засгийн 10 тунд ашиглах үржлийн өсөлтөөр хийгдэнэ. Үүнийг хялбархан хийж болно.”

НОТОНГООНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ

2024 онд төсвийн зарлагын шинжилгээг эрчим хүч болон байгаль орчны салбарт хийж байна.

'Бодлогын өртөг тооцоолох аргазүйн удирдамж'-ийг боловсруулах, улмаар ХХААХҮЯ-ны хөтөлбөр дээр турших ажлыг гүйцэтгэж байна.






QR кодыг уншуулан мэдээг уншина уу

2023 онд хийгдсэн 'Соёлын салбарын төсвийн зарлагын шинжилгээний тайлан' ба 'Биеийн тамир, спортын салбарын зарлагын шинжилгээ'-г хэвлэн нийтэллээ.



QR кодыг уншуулан мэдээг уншина уу





“Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлагнал” сургалт, 2024.01.17

ҮР ДҮНД СУУРИЛСАН ТАЙЛАГНАЛТ

“Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлагнал” сэдэвт хоёр өдрийн сургалт семинарыг улсын болон орон нутгийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын мэргэжилтэн зэрэг 120 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.

[Мэдээ унших холбоос](#)



QR кодыг уншуулан мэдээг уншина уу



QR кодыг уншуулан мэдээг уншина уу



Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг тайлагнах, нэгтгэх заавар, маягт-ыг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн ‘Заавар, маягт батлах тухай’ 225 тоот тушаалаар баталсан бөгөөд тус ажлыг хэрэгжүүлэхэд төслөөс мэргэжил, аргагүйн туслалцаа үзүүлж ажилласан.

ХНХЯ, ХХААХҮЯ болон ЭМЯ-ны 2023 оны жилийн тайланг батлагдсан заавар, маягтын

дагуу боловсруулах ажлыг хийн гүйцэтгэж байна.

‘Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлагнах, нэгтгэх’ системийг хөгжүүлж байна. Улсын болон орон нутгийн төсвийн 7,000 гаруй байгууллагын 2023 оны жилийн эцсийн тайланг уг системээр нэгтгэх бөгөөд 4 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

УИХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

· Дунд хугацааны төсвийн зарлагын хүрээ (ДХТЗХ) боловсруулахад дэмжлэг болох бодлогын судалгаа хийх ажлыг гүйцэтгэж байна.

· 'Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн төлөвлөлт болон хэрэгжилтэд УИХ-аас дүн шинжилгээ хийх аргачлал, зөвлөмж' боловсруулахаар ажиллаж байна.

· Тэрчлэн 'УИХ-ын гишүүдэд зориулсан төсвийн талаарх гарын авлага' боловсруулах ажлыг төлөвлөн, боловсруулалтын ажлыг эхлүүлээд байна.

· Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бий болгох дүрэм, журмын төслийг боловсруулахад УИХ-ын Төсвийн байнгын хороонд дэмжлэг үзүүлж ажилласан.

· Төсвийн тухай хуулийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд анх удаа төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтээр

хэлэлцүүлсэн байна.

· Төсвийн орлогыг бүрдүүлэх татварын ачааллын судалгааг татварын албаны сүүлийн 10 жилийн суурь мэдээлэлд үндэслэн хийж байна.

· Төсвийн татварын бус орлого болох төрийн үйлчилгээний төлбөр, хураамжийн талаарх судалгааг хийх асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг боловсруулахад туслалцаа үзүүлж ажилласан.

· Төсвийн байнгын хорооны даргын тэргүүлсэн баг Бүгд Найрамдах Филиппин Улс болон Тайландын Хаант Улсын Сенат, Танхим, Сенатын байнгын хороод болон яамдын төлөөллийг оролцуулсан олон талт уулзалт хийж, урт хугацааны төсвийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалт, үүний дотор татварын бодлогын хэрэгжилтийн талаар үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэв.



[Мэдээ унших холбоос](#)



"Урт хугацааны төсвийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх туршлага судлах уулзалт, 2024.03.12

ИНБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

• Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавихад залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг олгох зорилготой 'YOUTH IDEATHON 2024' уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд нийслэл, орон нутгийн төрийн байгууллага, их дээд сургууль, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, залуусын сайн дурын нэгдэл зэрэг салбар салбарын төлөөллөөс бүрдсэн 56 багийн нийт 180 гаруй залуус идэвхтэй оролцлоо.

 [Мэдээ унших холбоос](#)



[Хэвлэлийн мэдээ](#)



[Ярилцлага](#)



“YOUTH IDEATHON 2024” УРАЛДААНД ДАРААХ БАГУУД ШИЛДГЭЭР ШАЛГАРЛАА

- **Тэргүүн байр:** “Яасан бэ” баг (Сайн дурын бүлэглэл) Төсвийн гүйцэтгэлд үнэлгээ өгдөг цэсийг E-Mongolia вэб платформд оруулах замаар төсвийн хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх төсөл
- **Дэд байр:** “Dream high” баг (Монгол Улсын Их Сургууль) Төсөвтэй холбоотой асуулт, мэдээллийг гар утасны мессежээр залуучуудад хүргэж, тэдний оролцоо, ойлголтыг сайжруулах төсөл
- **Гутгаар байр:** “Хүсэл” баг (Шинжлэх ухаан, технологийн их сургууль) Төсвийн тухай ойлголт мэдлэгийг тоглоомон аппликэйшнээр дамжуулж олон нийтэд хүргэж, төсвийг хянахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх төсөл



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨДӨРЛӨГ 2024

· Үр дүнд суурилсан төсөвлөлт ба төлөвлөлт сэдвийн хүрээнд 3 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан нэг өдрийн сургалт-өдөрлөгийн үеэр хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл 30 гаруй сэтгүүлч, мэргэжилтэн өөрсдийн ойлголтыг сайжруулж, улмаар улсын төсөвтэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, олон нийтэд оновчтой байдлаар мэдээлэх чиглэлээр практик ур чадвараа нэмэгдүүллээ. УИХ-ын Төсвийн байнгын хороо, Сангийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн шийдвэр гаргах түвшний төлөөлөл оролцсон тус арга хэмжээг Эдийн засгийн сэтгүүлчдийн клубтэй хамтран зохион байгуулав.

 [Хэвлэлийн мэдээ](#)



“Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт” сэдэвт хэвлэл мэдээллийн өдөрлөг,
2024.03.22

MNB
MONGOLIAN NATIONAL BANK

gogo
MONGOLIA



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн аудитад төслөөс хамтран мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна.
- Төслөөс ‘Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн аудит’ хийх аргазүйн зөвлөмжийг боловсруулан, холбогдох сургалтыг Үндэсний аудитын газрын сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах ажлын хэсэгт зохион байгуулсан.
- Гүйцэтгэл, нийцлийн аудитын гарын авлага болон ТХЗ хэрэгжилтийн аудитын гарын авлагыг их дээд сургуулиудад танилцуулах, түгээх ажлыг хийлээ.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

· Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөл 'Иргэн төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, буюу хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ-профайлингийн үйлчилгээ'-г 2022 оноос улсын хэмжээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Үр дүнг танилцуулах уулзалтыг 2024 оны 3 дугаар сарын 5-ны өдөр нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймгийн хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудыг хамруулан цахимаар болон танхимаар хослуулан зохион байгууллаа. 2023 оны 8 дугаар сараас E-Job цахим системээр нийт 19,400 ажил хайгч иргэнд 'Профайлинг буюу хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ'-г хийсэн байна. Тухайн мэдээллийг шинжлэн энэхүү үйлчилгээнээс гарах үр дүнг багцлан танилцуулсан нь нотолгоонд суурилсан үйлчилгээ нэвтэрч байгаагийн нэг илрэл боллоо.



[Мэдээ унших холбоос](#)




[Мэдээ унших холбоос](#)



"Профайлинг
үйлчилгээний үр
дүнг танилцуулах
семинар, 2024.03.05

· Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлал батлагдсан бөгөөд энэ үзэл баримтлалтай уялдуулан хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг хууль, тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, оролцогч талуудын саналыг тусгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн хэлэлцүүлэх, танилцуулах, санал авах уулзалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.



"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалын харьцуулсан зураглал

- Хувийн хэвшлээр хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэх боломжийг судлан, тайлан гаргаж, үр дүнг танилцуулах, санал солилцох уулзалтыг хөдөлмөрийн хувийн бирж, хөдөлмөрийн хувийн биржийн холбоог оролцуулан зохион байгууллаа. Уулзалтаар гарсан санал, зөвлөмжийг үндэслэн хөдөлмөрийн хувийн биржид санхүүжилт олгох журмын төслийг шинэчлэн боловсруулан ХНХЯ-нд хүргүүлсэн.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас иргэдэд олгож буй санхүүгийн дэмжлэг олгох, арга замыг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, судалгааны үр дүнд үндэслэсэн бодлогын шийдлүүдийг боловсруулан ХНХЯ, ХХҮЕГ, Монголын бизнес инкубаторуудын холбоо, бизнес бойжуулагч, хурдасгуур хөтөлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, ЖДҮ-ийн зөвлөх үйлчилгээний байгууллага, бизнесийн эрсдэл, зээлжих чадварын үнэлгээний чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн байгууллагын төлөөлд танилцуулах уулзалтыг зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журамд тусгах санал, зөвлөмжийг ХНХЯ-нд хүргүүлсэн.

 **Мэдээ унших холбоос**



- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг сайжруулах зорилгоор судалгааны ажлыг хийж байна. Энэ ажлын хүрээнд 'Ажил мэргэжлийн баримжаа нэр томъёоны тайлбар толь'-ийг боловсруулан гаргаад байна.

- 'Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөл'-ийн хэрэгжилтийг хангах чиглэлд менежментийн багийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар дээр ажиллуулж байгаа бөгөөд 2024 онд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус төсөл 7 тэрбум төгрөгийг төсөвлөн 5,000 орчим иргэнийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

- Ажил олгогч байгууллагуудад иргэний хөгжлийн бэрхшээлийн төрлүүд, тэдгээрийн онцлогуудын талаар мэдээлэл өгөх, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон дэмжлэгийг ажлын байранд хэрхэн үзүүлэх, ажлын байрны дадлагажуулагчийн тусламжтайгаар ХБИ-ийн тогтвортой

хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг танилцуулсан уулзалт, сургалтыг зохион байгуулсан. Энэ сургалтанд нийт 50 орчим байгууллагын хүний нөөцийн менежер болон ХБИ-тэй ажилладаг ажилтан албан хаагчдын дунд зохион байгууллаа.

 [Мэдээ унших холбоос](#)



“Ажил олгогчийн сургалт, 2024.02.22

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ

· Боловсролын олон улсын стандарт ангилал (ICSED - БОУСА)-д нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индексийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11 өдрийн А/11 тоот “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд тус ажлыг хэрэгжүүлэхэд төслийн зүгээс техник туслалцаа үзүүлж ажилласан.



 [Мэдээ унших холбоос](#)

МБС-ын индексийг хэлэлцүүлэх семинар, 2023.11.30

· 2024 он 03 дугаар сарын 25-ны өдөр “Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн талаар санал солилцох уулзалт” оролцогч талуудын дунд зохион байгуулж, нийт 28 холбогдох талууд хамрагдсан. Үндэсний мэргэшлийн хүрээний удирдамжийн агуулгыг хамтран боловсруулж, төслийг хүлээн аваад байна.

СУДАЛГАА, ҮЙЛДВЭРЛЭЛТИЙН ТУРШИЛТ

НҮБ-ын ХХААБ-аас ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуультай хамтран мал төхөөрөх үйлдвэрээс гарч буй дотор мах, дайвар түүхий эдийг ашиглан эрүүл мэндийн ач холбогдол бүхий нэмэлт бүтээгдэхүүний технологи, техникийн бичиг, баримтыг боловсруулах судалгааны ажлыг хийж байна. Энэ судалгааны хүрээнд дотор, дайвар түүхий эдийн хадгалалтад тэсвэргүй, хурц, содон үнэр, амттай, боловсруулахад төвөгтэй байдаг ул тэдгээрийг боловсруулах технологийн үр ашигтай шийдлийг гарган, нэмүү өртөг шингэсэн, шим тэжээллэг нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Туршилт судалгааны үр дүнд үндэслэн дотор маханд суурилсан хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх загвар үйлдвэрийн төсөл боловсруулан, түүнтэй уялдсан бүтээгдэхүүний технологийн заавар, үйлдвэрлэлд мөрдөх GMP, GHP утгвар хөтөлбөрүүдийг боловсруулах эхний шатны судалгаа хийгдээд байна. Энэхүү судалгааны хүрээнд дараах үндсэн туршилтын ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

• Судалгааны дээж болох бэлчээрийн монгол хонины цул ба салслаг дотор мах, цусны нийт 11 төрлийн дээжийн химийн ерөнхий үзүүлэлтийг тодорхойллоо.

• Хонины дотор маханд суурилсан нэмэлт бүтээгдэхүүний технологи боловсруулахад суурь судалгаа болох хатаалтын туршилтуудыг уламжлалт дулааны болон вакум хатаалтын аргуудад тулгуурлан гүйцэтгэв.

• Хатаасан бүтээгдэхүүний онцлог, шинж чанарт тохирсон савлагааны шийдлүүдийг туршилт судалгааны дүнд бий болголоо. Тухайлбал, хатаасан цул дотор махны хувьд (элэг гэх мэт) бортгонцор болон шахмал хэлбэр, харин салслаг түүхий эдийн (гүзээ гэх мэт) хувьд вакум савлагааны хэлбэрийг тодорхойлов.

Судалгааны үр дүнд үйлдвэрт нэвтрүүлэх боломжтой хатаалтын технологи, шаардлагатай тоног, төхөөрөмжийн жагсаалт, техник үзүүлэлтүүдийг боловсруулж гаргав. Түүнчлэн дээрх технологийг өөрийн үйлдвэрт туршин нэвтрүүлж, цаашид өртөг шингэсэн дотор, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолтой хэд хэдэн аж ахуй нэгж байгууллагууд хамтран ажиллах хүсэлтэй ирүүлээд байна.

НҮБ-ын ХХААБ-ын зүгээс хүсэлт ирүүлсэн үйлдвэрүүдийн ажлын байр, үйлдвэрлэлийн нөхцөлд үнэлгээг үнэлж, цаашид мэргэжлийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллах судалгааны шатандаа явж байна.

ДОТОР МАХНЫ ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОГООЧ, ХООЛ ЗҮЙЧДИЙН УР ЧАДВАРЫН УРАЛДААН

НҮБ-ын ХХААБ, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль хамтран бэлчээрийн малын дотор мах, дайвар бүтээгдэхүүн ашиглан хүүхдийн хоолны шинэлэг жор боловсруулах “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол зүйч, тогоочдын ур чадварын уралдаан”-ыг Төв болон Улаанбаатар хотод амжилттай зохион байгууллаа. Уралдаанд цэцэрлэг, сургуулийн нийт 51 тогооч, хоол зүйч нар бэлчээрийн малын дотор махаар хийсэн хоолны 100 гаруй шинэлэг жор, технологиороо оролцов.

Энэхүү ур чадварын уралдаан нь биологийн идэвхт нэгдлээр баялаг дотор махан бүтээгдэхүүнийг хүүхдүүд бага наснаасаа хэрэглэж дасах, цаашид хэрэглээг нэмэгдүүлэх хандлагыг хэвшүүлэх зорилготой юм. Түүнчлэн малын дотор махны хүнс тэжээлийн үнэ цэнэ болоод хэрхэн бэлтгэж хэрэглэх талаар эцэг, эхчүүд, цаашид нийт хэрэглэгчдийн мэдлэг тэлснээр энэхүү үнэт түүхий эдийн ашиглалт сайжирч, нэмүү өртгийн сүлжээ бэхжих эерэг үр дагавартай юм.

Уралдааны дүнд хүүхдэд тохиромжтой дотор махан шинэлэг хоолны нэр төрөл нэмэгдэх, сургууль, цэцэрлэгийн хоолзүйч, тогооч нарын ур чадвар дээшлэх ач холбогдолтой. Түүнчлэн малын дотор махны хүнс тэжээлийн үнэ цэн болоод хэрхэн бэлтгэж хэрэглэх талаар тогоочдоос гадна эцэг, эхчүүд, цаашид нийт хэрэглэгчдийн мэдлэг тэлснээр энэхүү үнэт түүхий эдийн ашиглалт сайжирч, нэмүү өртгийн сүлжээ бэхжих эерэг үр дагавартай юм.

Төв аймаг, Улаанбаатар хотын цэцэрлэг, сургуулийн хоол зүйч, тогооч нарын дунд зарлагдсан “Малын дотор мах ашиглан хүүхдийн физиологи, таашаалд нийцтэй шинэлэг хоолны жор, технологи боловсруулах” ур чадварын уралдааныг амжилттай зохион байгуулав.



51



Сургууль, цэцэрлэгийн нийт 51 тогооч, хоол зүйч нар уралдаанд оролцов.



Дотор махаар хийсэн нийт 100 гаруй төрлийн хоолны шинэлэг жор, технологийг гаргав.



Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд эрдэс бодис, уургаар баялаг малын дайвар дотор махан бүтээгдэхүүнийг ашиглах нь хоол, хүнсний нэр төрөл олшруулах, хэрэглээг нэмэгдүүлэх, түүнчлэн хоолыг илүү шим тэжээллэг болгох зэрэг олон ач холбогдолтой. Уралдаанд оролцсон тогооч нарын шилдэг жор, технологийн карт бүхий хоолны ном эмхэтгэл удахгүй хэвлэгдэн гарах болно.

 [Мэдээ унших холбоос](#)

 [Мэдээ унших холбоос](#)

ШИНЭ АГРОПРЕНЁР ЗАЛУУЧУУДАД ТЕХНИК АРГА ЗҮЙ, МАРКЕТИНГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

“Agripreneurship Challenge” тэмцээний ялагч залуу бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн (“Мэжик би фүүдс” ХХК, Спек материалс ХХК, Аере Фэлт ХХК) бизнес эхлүүлсэн түүх, бизнесийн онцлог, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн процесс, харуулсан танилцуулга видео контент бэлтгэн, мэдээллийн сувгуудаар цацав.

Мэжик би фүүдс ХХК

 [Видео үзэх холбоос](#)

Спек материалс ХХК

 [Видео үзэх холбоос](#)

ШИНЭ АГРОПРЕНЁРС ТҮҮХ:

Тэнгэр ТВ-тэй хамтран “Шинэ агропренёрс түүх” цуврал 5 контентыг бүтээж байна. Тус контент нь хөдөө ахуйн салбарт шинэлэг шийдэл, бүтээлч санаачилгаараа тэсрэлт хийж, өөрсдийн хийж буй төсөл, бизнесээрээ бодит нөлөөлөл үзүүлж, олон нийтийн боловсрол, зан төлөвт эерэг хувь нэмэр оруулж буй түүх, хувь хүмүүсийг онцолсон цуврал нэвтрүүлэг юм.



“Шинэ агропренёрс түүх” цуврал нэвтрүүлэг:

 [Нэвтрүүлэг үзэх холбоос](#)

ОНЦЛОХ БИЗНЕС SPOTLIGHTS:

TenGer ТВ-ээр тогтмол цацагддаг “Онцлох Бизнес Spotlights” нэвтрүүлэгтэй хамтран мөн зах зээлд онцлох, шинэ санаа дэвшүүлж, сонирхолтой шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж буй стартап, бизнесүүдийг таниулах зорилготой 3 цуврал нэвтрүүлгийг бүтээгээд байна.

- Онцлох бизнес видео контент, Жаргалант Милк:
- Онцлох бизнес видео контент, Аере Фэлт ХХК, Агаар шүүгч
- Онцлох бизнес видео контент, Амгаланзаяа ХХК, Цайны ургамал

“Agripreneurship Challenge” тэмцээний ялагч залуу бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийг таниулах, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор компанийн албан ёсны танилцуулга, цахим хуудас, чатбот, мөн бүтээгдэхүүний каталог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Шинэ бүтээгдэхүүний каталог хөгжүүлэлтийг хийснээр тухайн бүтээгдэхүүнийг олон улсын болон дотоодын зах зээлд таниулах, борлуулалт нэмэгдүүлэх боломж бүрдээд байна.



ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

· Үндэсний статистикийн хорооноос улирал бүр гаргадаг “Ажиллах хүчний судалгаа (АХС)”-ны мэдээлэл цуглуулах асуулгын хуудсыг Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 20 дугаар бага хурлын “Хөдөлмөрийн харилцааны статистик”-ын тогтоол, 21 дүгээр бага хурлын “Албан бус эдийн засгийн статистик”-ийн тогтоолд нийцүүлэн шинэчлэв.

· Төслийн хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 187 дугаар конвенцод нэгдэн орохын ач холбогдлыг харуулсан зургаан төрлийн зурагт хуудсыг боловсруулав.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ
ТОГТӨЛЦООНЫ ТУХАЙ ОУХБ-ЫН 187-Р КОНВЕНЦОД НЭГДЭН ОРСНООР ...

бүх ажилтан, үүний дотор өндөр эрсдэлтэй салбарын ажилтнууд эрүүл, аюулгүй ажилын байраар хангагдаж, хөдөлмөрийн нөхцөл нь улам сайжирна.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй нийт хүн ам
1,180,000 ХҮН
ҮҮНЭЭС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС
ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ САЛБАРТ АЖИЛЛАГСАД:

Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа
6,800 хүн

Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа
68,200 хүн

Уул уурхай, олборлолт
60,300 хүн

Цахилгаан, хий, уур, агааржуулалт
22,000 хүн

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
294,000 хүн

Боловсруулах үйлдвэрлэл
112,700 хүн

Барилга
77,500 хүн

“Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн дэмжлэгээр бүтээв.



2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН ТАЙЛАН, ГАРЫН АВЛАГА



[Тайлан татах](#)




[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



[Тайлан татах](#)



Төслийн холбоо барих хаяг

Монгол Улс, Улаанбаатар 14201
Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж - 14
Нэгдсэн Үндэстний байр
Утас: 976-11-32785